



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/09

Мандалговь

“Бизнес эрхлэгчдийг дэмжих жил”
болгон зарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн “а”, 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, Коронавируст халдвар/ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6, аймгийн Засаг даргын 2020-2024 оны “Дундговь хөгжинэ” үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.4, 3.3.1.5, 3.3.1.6, 3.3.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Орон нутгийн хэмжээнд төр, хувийн хэвшил, иргэдийн хамтын ажиллагаанд түшиглэсэн бизнесийг хөгжүүлэн, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор 2021 оныг “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил” болгон зарласугай.

Хоёр. Бизнес эрхлэгчдийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөг бизнес эрхлэгчдийн санал, эрэлт хүсэлтэд тулгуурлан боловсруулан батлуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, биелэлт үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), төлөвлөсөн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга, газар, хэлтэс, албадын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Орон нутагт бүртгэлтэй аж ахуйн нэгжийг худалдан авах ажиллагаанд оролцоход давуу эрх олгох замаар дотоодын ажлын байрыг хадгалах, бизнес эрхлэгчдийн ашиг орлогыг нь хамгаалах, нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, хамтран ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат)-д даалгасугай.

Дөрөв. Орон нутагт бизнесийг хөгжүүлэхэд бүтээлч санаачилга, бодитой үр дүн гаргаж хамтран ажиллахыг аймгийн нийт бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгж, байгууллагуудад уриалсугай.

ЗАСАГ ДАРГА  Ц. МӨНХБАТ



481210097